

## **НУМЫН ЯСАН НААЛТ ДЭЭРХ БИЧЭЭС**

**А.ОЧИР<sup>1</sup>, Ц.БАТТУЛГА<sup>2</sup>**

<sup>1</sup>ШУА-ийн Археологийн Хүрээлэн,

<sup>2</sup>МУИС-ийн Гадаад хэл соёлын сургууль, Түрэг судлалын төв,

e-mail: ts\_battulga@yahoo.com

**Түлхүүр үгс:** Архангай аймаг, Хотонт сум, Хулхийн амны Дөрвөлжин, нумын ясан наалт, руни бичиг

**Өгүүллийн товч агуулга:** Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хулхийн амны Дөрвөлжинд хийсэн малтлага судалгааны үр дүнд бунхант оршуулгаас хоёр ширхэг ясан наалт олдсон юм. Уг наалтны нэг нь руни бичээстэй нөгөө нь бичиг, тамга тэмдэггүй ажээ. Нумын наалт нь 5 үсэг бүхий бичээстэй бөгөөд эл бичээсийг уншсанаа толилуулж байна.

Монголын Үндэсний Түүхийн Музей, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, БНХАУ-ын Өвөр Монголын Соёлын өв, археологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан судалгааны анги 2006 оноос Архангай аймгийн Хотонт сумын нутагт археологийн малтлага судалгаа хийж байгаа билээ.

Хоёр улсын хамтран зохион байгуулсан энэхүү судалгааны явцад Хотонт сумын нутаг Хулхийн амны Дөрвөлжин хэмээх газраас 2007 онд 2 ширхэг нумын ясан наалт олдсон юм (**Зураг 1**). Газрын хөрсөн доогуур хөндийлөн ухаж, шатаасан хөх, улаан тоосгоор доторлож, шалласан бунхан дотор нэгэн настай эрэгтэй хүнийг оршуулжээ. Хоёр ширхэг ясан наалт олдсон энэ бунхант булшийг судлаачид 14-р булш хэмээн дугаарлаж тодорхойлсон байна. Эл хоёр ясан наалтын нэг дээр нь 5 үсэг бүхий руни бичээстэй бөгөөд бичээсийг хурц үзүүртэй зүйлээр зурчиж бичжээ (**Зураг 2**). Бичээстэй, бичээсгүй энэ хоёр ясан наалт одоо Монголын Үндэсний түүхийн музейн сан хөмрөгт Y2007-2-39 гэсэн бүртгэлийн дугаартай хадгалагдаж байгаа болно.

Ясан наалтууд нь цагаан шаргал өнгөтэй бөгөөд хоёр үзүүр лүүгээ хурц өнцөг бүхий шувтан хэлбэртэй. Нумын үүсгүүрт наах хэсгээрээ хавтгай бөгөөд нөгөө тал нь бага зэрэг төвгөрдүү. Голоороо бага зэрэг зузаан, гадна ирмэг тийшээгээ нимгэн. Наалтын их биеийг хөвөөлүүлж хооронд нь огтлолцуулан гүн бус зурчмал хээ гаргажээ. Руни бичээст нумын наалт 16.3 см урт, 2.2 см өргөн, 0.2-0.4 см зузаан юм. Бичээсгүй наалт 16.5 см урт, 2.2 см өргөн, 0.2-0.4 см зузаан болно.

Бичээсийн үсгийн хэлбэр тогтсон, үсэг тэмдэгтийг жигд, тун чадварлаг бичсэн зэргээс үзэхэд бичээч руни бичгийг эзэмшсэн нэгэн байсан нь илт ажээ.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

Ч>>>^


Бичээсийн үсгийн галиг:

T W N W z

Бичээсийн үгийн галиг:  
Tunuz (tonuz)



Зураг 1. Нумын ясан наалт олдсон байдал



0 2 см

Зураг 2. Руни бичиг бүхий нумын ясан наалт

Тайлбар: Руни бичигт ц, о эгшгийг > гэсэн нэг тэмдэгтээр илэрхийлдэг тул Туруз, Тонуз гэсэн хоёр хувилбараар уншиж болох юм. Туруз, Тонуз гэдэг нь хүний

нэр хэмээн бид үзэж байна. Эртний түрэг хэлний ᠳᠤᠠ tun хэмээх язгуур үг нь “ууган, анхны” гэсэн утгатай. Харин ᠳᠤᠠ ton язгуур нь “дээл, хувцас” гэх утгатай билээ. Монголын руни бичгийн дурсгалуудад ᠳᠤᠠ ton, tun язгууртай хүний нэр цөөнгүй тохиолдоно.

Нум төдий л элэгдэж хуучраагүй, үсэг тэмдэгт нь бүдгэрч балрах хэмжээний хэрэглэгдээгүй, бараг шинэ мэт байгаа нь сонирхолтой юм.

Тунуз, Тонуз нь тухайн нумыг эзэмшигч язгууртны нэр үү, эсвээс нумын ясан элэг наалтыг үйлдэж хийсэн хүний нэр үү гэдэг нь ихээхэн анхаарал татаж байна.

Бидний санахад энэ нь уг нумыг эзэмшигч язгууртны нэр бус харин нум үйлдэж язгууртан эзэндээ дурсгасан хүний нэр байж болох юм.

Учир нь бунхан байгуулж тусгайлан хүндэтгэл үзүүлэн оршуулж байгаа энэ язгууртанд зориулсан бол тэр хүний алдар цол, хэргэм зэргийг эрхбиш бичих байсан болов уу. Монголын руни бичгийн сонгодог болон бага бичгийн дурсгалуудаас тухайн язгууртны нэрээс илүүтэй цол, хэргэм зэргийг нь заавал бичдэг тогтсон уламжлалтай байсныг бэлхэнээ мэдэж болно. Өөрөөр хэлбэл, энэ нь тухайн үеийн албан бичгийн найруулгын нэг онцлог билээ.

Монголын руни болоод уйгур бичгийн дурсгалуудад аян дайн, байлдааны тухай тэмдэглэгдсэн нь цөөнгүй боловч тэдний нум сум, зэр зэвсгийн талаар өгүүлсэн баримт мэдээ байдаггүй билээ. Тэгвэл эл олдвор нь эртний уйгур нарын нум сумын талаарх бодит баримт болж байгаагаараа шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой юм. Түүгээр ч үл барам нумын гарал үүслийг тодруулан судлахад ч тустай болохыг өгүүлэх юун.

Нумын наалт дээрх эл бичээс он цагийн хувьд Түрэгийн хаант улсын сүүл, Уйгурын хаант улсын эхэн үед, харин бунхант оршуулга нь уйгур нарт холбогдох болов уу хэмээн үзэж байна.

## SUMMARY

A.Ochir, Ts.Battulga

### NEWLY DISCOVERED RUNIC INSCRIPTION

In 2007, during archaeological excavations in Khotont soum, Arkhangai aimag, an inscription on the bone piece of the bow gridle was unearthed in inside section of a burial camera of the mausoleum. The inscription consists of 5 runic letters and designed the personal name “Tonuz” or “Tunuz” of a men whom, probably belonged the bow.

According to the chronological frame of the artefacts and other evidencies the inscription could be dated back to the late Old Turkic and early Uighur periods.

#### Origin of the inscription:

ᠳᠤᠠ

#### Transliteration:

T W N W z

#### Transcription:

Tunuz (tonuz)